

# Транспэрэнси Интернэшнл

Монгол



## Хүүхэд хамгааллын бодлого ба журмууд

Бодлого хариуцагч	Б. миа
Баталсан	О.Батбаяр
Гаргасан огноо	2018 оны 11 сарын 16
Бодлогыг хянах огноо	2019 оны 12 сар

## Танилцуулга

*Транспэрэнси Интернэшнл Монгол ТББ* –ын эрхэм зорилго нь засаглал, улс төр, бизнес, иргэний нийгэм болон хүмүүсийн өдөр тутмын амьдралд авлигагүй ертөнцийг байгуулах юм. Өөрийн үйл ажиллагаагаар, авлига болон сайн засаглалын талаарх мэдээлэл ба мэдлэгийг хуримтлуулах ба түгээх замаар, мөн авлигатай тэмцэхэд нэмэр болох шинэ бүтээгдэхүүн ба хэрэгслүүдээр дэлхий нийтийн буюу бүс нутгийн хэмжээний асуудлуудыг үр дүнтэйгээр шийдвэрлэн авлигын эсрэг дэлхий нийтийн хөдөлгөөнийг дэмжихэд оршино.

*Транспэрэнси Интернэшнл Монгол ТББ* нь Хүүхэд хамгааллын бодлогыг дараах зорилгоор боловсруулсан. Үүнд:

- *Транспэрэнси Интернэшнл Монгол ТББ*-ын хөтөлбөрт хамрагдах хүүхдүүдийг хүчирхийлэл болон мөжлөгийн бүх хэлбэрээс хамгаалах;
- Зохисгүй зан байдлын талаар худал хуурмаг мэдэгдэл эсхүл бусдыг санаатай хорлох гэсэн мэдэгдлээс ажилтнуудыг хамгаалах;
- Хүүхдийг хүчирхийллээс урьдчилан сэргийлэх, хамгаалахад чиглэсэн “үндэслэлтэй алхам” хийгүйдээс болж хариуцлагад унах эрсдэлээс *Транспэрэнси Интернэшнл Монгол ТББ*-ийг хамгаалах;
- Австралийн Засгийн газрын тусламжийн хөтөлбөрт зориулсан Хүүхэд хамгааллын бодлогыг мөрдлөг болгох.

*Транспэрэнси Интернэшнл Монгол ТББ*-нь хүүхдийг хамгаалах, тэдний аюулгүй байдал, сайн сайхныг баталгаажуулахад үүрэг, амлалтаа өгсөн болно.

Бид Нэгдсэн үндэстний байгууллага (НҮБ)-ын Хүүхдийн эрхийн конвенцид заасан хүүхдийн эрх, үүргийг дээдэлж, хүүхдийг хор хөнөөл, мөжлөг, хүчирхийллээс хамгаалахад өөрсдийгөө зориулдаг.

*Транспэрэнси Интернэшнл Монгол ТББ*-нь хүүхэдэд хор хөнөөл хүргэж болзошгүй эрсдлийг олж тогтоон шийдвэрлэснээр хүүхэдтэй ажиллах хамгийн аюулгүй орчныг бүрдүүлэх зорилготой.

Хэрэгжүүлж буй хөтөлбөрүүдийнхээ үр дүнг хүүхэдэд “ямар ч хор хөнөөлгүй” байлгахын тулд бид байгууллагынхаа хүрээнд хүүхэд-аюулгүй түршлэгүүдыг хөхиүлэн дэмждэг.

### 1. Бодлогын талаар товч

*Транспэрэнси Интернэшнл Монгол ТББ*-нь өөрийн хөтөлбөрүүд ба үйл ажиллагаанд хамрагдсан хүүхдүүдийг хамгаалахад чиглэсэн анхаарал, халамж тавих үндсэн үүрэгтэй гэдгээ ойлгож, хүүхдийг бүх төрлийн хүчирхийлэл, мөжлөгөөс хамгаалах, аюулгүй байлгахад үүрэг, амлалтаа өгч байна. Энэхүү Хүүхэд хамгааллын бодлого нь хүүхэд туйлын эмзэг гэдгийг, ялангуяа ядуу эсхүл хүмүүнлэгийн хямрал, зөрчилтэй нөхцөлд буй хүүхдийг хамгаалах шаардлагатай гэдгийг хүлээн зөвшөөрч байгаа болно.

*Транспэрэнси Интернэшнл Монгол ТББ* нь хүүхэд хүчирхийлэлд автах магадлалыг бууруулахад чиглэсэн эрсдэлийн менежментийн арга хэрэглэх ба байгууллагын ажилтан, төлөөлөгчдийг хүүхдийн эсрэг хүчирхийлэлд хариу өгөх, санал гомдлыг шийдвэрлэхэд нь тодорхой, бодит удирдамжаар хангах болно.

Энэ бодлогыг НҮБ-ын Хүүхдийн эрхийн конвенц, мөн Австралийн Засгийн газрын тусламжийн хөтөлбөрт зориулсан Хүүхэд хамгааллын бодлого (2013) зэрэг олон улсын стандартад нийцүүлэхийн

тулд боловсруулав. Энэ нь уламжлалт (Ром-Германы) эрх зүйн бүл ба парламентаар батлагддаг (Англо Саксоны) эрх зүйн бүлтэй холбоотойгоор хэрэгжих бөгөөд Монгол Улсын үндсэн хуулинд заасан хувь хүний эрх, үүргийг хүчингүй болгож, орлохгүй болно.

Бодлогыг *Транспэрэнси Интернэшнл Монгол ТББ*-ын биеэ хэрхэн авч явах тухай дүрмийн болон ёс зүйн илүү өргөн хүрээнд хийгдэх ажлуудын бүрэлдэхүүн хэсэг болгон харах ёстой. Сахилгын үйл явцууд нь ёс зүйтэй, үр ашигтай, үр нөлөөтэй байгууллага бий болгож, авч явах хэрэгсэл бөгөөд үүнийг байгууллагын нийт зорилгоос салангид авч үзэх ёсгүй.

## 2. Зорилго

Хүүхэд хамгааллын бодлого нь дараах зүйлст хүрэх зорилготой. Үүнд:

Хөтөлбөрүүдийн дүнд хүүхдэд “ямар ч хор хөнөөлгүй” байх зорилго тавьснаар хүүхдийг хор хөнөөл, мөлжлөг, хүчирхийллээс хамгаалах. Хүүхэдтэй ажиллахад гарах эрсдэлийг олж тогтоон эрсдэлийн менежмент гаргах, мөн хүүхэд хамгаалалтай холбоотой санал гомдлыг шийдвэрлэх байгууллагын дотоод журам гарган уг журмыг бүх ажилтанд баттай мэдүүлэх зэргээр энэ зорилтод хүрнэ;

Тодорхой, ил тод тайлагнах тогтолцоог бий болгосноор хэтэрхий их сэжиглэх эсхүл буруу мэдэгдэл үүсэхээс *Транспэрэнси Интернэшнл Монгол ТББ*-ийн ажилтан, төлөөлөгчдийг хамгаалах; Хүүхдийн эсрэг бэлгийн хүчирхийлэл үйлдэгчдийг Хүүхэд хамгааллын бодлого ба холбогдох журмуудаар таслан зогсоосноор *Транспэрэнси Интернэшнл Монгол ТББ*- ба түүний түншүүдийн институцийн бүрэн бүтэн байдал болоод нэр хүндийг хамгаалах.

Энэ бодлого нь дараах зүйлсийг тодорхойлно. Үүнд:

- Хүүхдийн эсрэг хүчирхийлэл болон бусад холбогдох нөхцлийг тодорхойлох;
- Хүүхэд хамгааллын хууль тогтоомж, конвенци, удирдамжуудыг тодорхойлох;
- *Транспэрэнси Интернэшнл Монгол ТББ*-ын хүүхэд хамгаалах цогц үүрэг, амлалт;
- *Транспэрэнси Интернэшнл Монгол ТББ*-ын хүүхдийн эсрэг хүчирхийлэл, мөлжлөг гарах магадлалыг бууруулах эрсдэлийн менежментийн арга зам;
- *Транспэрэнси Интернэшнл Монгол ТББ*-ын хүүхэдтэй харилцахдаа биеэ хэрхэн авч явах тухай дүрэм
- *Транспэрэнси Интернэшнл Монгол ТББ*-ын бодитоор тайлагнах журам ба хариу өгөх механизм.

## 3. Хамрах хүрээ

Бодлогыг дараах хүмүүс хэрэглэнэ. Үүнд:

*Транспэрэнси Интернэшнл Монгол ТББ*-ын дотоод, гадаадад буй аливаа ажилтан (үүнд бусад байгууллагад томилон ажиллуулж буй ажилтнууд багтана), гэрээлэгчид, туслах гүйцэтгэгчид, аялж буй удирдлагын гишүүд, хөтөлбөрт оролцогчид (тухайлбал, сайн дурынхан, тэтгэлэг авагчид, сургагчид, бүлгийн ахлагчид, сургалтын удирдагчид), дагалдаж буй хүмүүс болон гэр бүлийн гишүүд багтана.

## 4. Нэр томъёоны тодорхойлолт

**Хүүхэд** гэдэг нь 18-аас доош настай хүн бүрийг хэлнэ.<sup>1</sup>

<sup>1</sup> Хүүхдийн эрхийн конвенцид тодорхойлсон ёсоор (НҮБ, 1-р бүлэг).

**Хүүхдийн эсрэг хүчирхийлэлд** хариуцлага, итгэл, эрх мэдлийн харилцааны хүрээн дэх хүүхдийн эрүүл мэнд, амь нас, өсөлт хөгжил ба нэр хүндэд бодит эсхүл боломжит хор хөнөөл үүсэхэд хүргэх бие махбодын ба бэлгийн хүчирхийлэл, сэтгэл санааны дарамт, хүүхдийг үл хайхрах явдал багтана.

**Хүүхэд хамгаалал** нь хүүхдийг аливаа хор хөнөөлөөс хамгаалах, ялангуяа хүчирхийлэл, үйл хайхрах явдал, (хөдөлмөрийн ба бэлгийн) мөлжлөгөөс үүдэн гарах хор хөнөөлөөс хамгаалахад чиглэсэн үйл ажиллагаа эсхүл санаачилга юм.

**Хүүхдийн эсрэг бие махбодын хүчирхийлэл** гэдэг нь хүүхдийн өмнө хариуцлага, эрх мэдэл, итгэл хүлээсэн хүний хараа хяналтад байх боломжтой харилцаа эсхүл харилцааны дутмаг байдлаас болж хэн нэгэн хүүхдийг санаатайгаар бэртээж, гэмтээх эсхүл ингэх гэж оролдохыг хэлнэ. Үүнд хүүхдийг алгадах, цохих, сэгсрэх, өшиглөх, түлэх, түлхэх, шидэх, шүүрч барих эсхүл бие нь өвдөж байхад туслахгүй байх зэрэг багтана. Тухайн хүчирхийлэл нь нэг удаа эсхүл удаа дараалан тохиолдсон байж болдог.

**Сэтгэл санааны дарамт** нь бие махбодын бус харин хүүхдийн нийгмийн, оюуны эсхүл сэтгэл санааны хөгжилд сөргөөр нөлөөлдөг. Өөрөөр хэлбэл, хүүхдийн өөрийгөө үнэлэх үнэлэмж ба нийгмийн ур чадварыг нь цаг хугацааны явцад бууруулах, үгүй хийх зэргээр хүүхэд рүү чиглэсэн удаан хугацааны зохисгүй зан байдлын хэв маяг юм. Үүнд хүүхдийг хараан доромжлох, заналхийлэх, дорд үзэх, дооглон тохуурхах, айлган сүрдүүлэх, тусгаарлах, үл ойшоох, эсхүл дайсагнах эсхүл хүүхэдтэй харилцахаас татгалзах зэрэг сэтгэл санааны дарамтын бусад хэлбэр багтана.

**Хүүхдийг үл хайхрах явдал** гэдэг нь хүүхдийн гэр бүл, асран халамжлагч нь бүрэн нөөц, бололцоотой хэрнээ хүүхдийг үндсэн хэрэгцээ болох хоол хүнс, хувцас, орон байр, боловсролоор хангах, мөн сэтгэл санааны хөгжлийг хянан харгалзаж байх эсхүл урьдчилан харах боломжтой хор хөнөөлөөс хамгаалах зэрэг үүргээ биелүүлээгүйгээс болж хүүхдийн эрүүл мэнд эсхүл өсөлт хөгжил эрсдэлд орохыг хэлнэ.

**Хүүхдийн эсрэг бэлгийн хүчирхийлэл** гэдэг нь хүүхдийн өмнө хариуцлага, итгэл, эрх мэдэл хүлээсэн хүн хүүхдийг сексийн талаар бүрэн гүйцэт ухамсарлаж ойлгоогүй, энэ талаар хүлээн зөвшөөрсөн эсэхээ мэдэгдэх боломжгүй, биеийн хөгжлийн хувьд бэлэн болоогүй, зөвшөөрсөн эсэхээ мэдэгдэж чадахгүй үед нь бусдын хэрэгцээг хангах зорилгоор бэлгийн үйл ажиллагаанд татан оролцуулахыг хэлнэ. Үүнд биеэр хавьтах (хүчиндэх эсхүл секс хэлбэрээр хүрэх) эсхүл биеэр бус хавьтах (порнографар гаргах эсхүл хүүхдийн секс зураг авах) багтана.

**Гэр бүлийн хүчирхийлэл** нь гэр бүлийн орчин эсхүл орон нутгийн (гэр орны) орчинд болдог хэрцгий түрэмгий эсхүл албадсан зан байдлын хэв маяг бөгөөд үүнд бие махбодын ба бэлгийн хүчирхийлэл, сэтгэл санааны дарамт эсхүл эдийн засгийн албадлага багтана.

**Хүүхдийн мөлжлөг** гэдэг нь бусдын ашиг хонжооны зорилгоор хүүхдийг ажиллуулах, бусад үйл ажиллагаанд ашиглахыг хэлнэ. Үүнд **хүүхдийн (арилжааны зориулалттай) бэлгийн мөлжлөг** (хүүхдийг мөнгөн эсхүл бараа, үйлчилгээний ашиг олох зорилгоор бэлгийн хүчирхийлэлд автуулах) болон **хүүхдийн хөдөлмөрийн мөлжлөг** (бие махбодын, нийгмийн эсхүл оюуны хөгжилд нь хор хөнөөлтэй байх хэмжээнд хүүхдээр ажил хийлгэх, бусад үйл ажиллагаа гүйцэтгүүлэх) зэрэг багтах бөгөөд зөвхөн эдгээрээр хязгаарлагдахгүй.

#### Бодлогод баримтлах зарчмууд

Энэ бодлого нь дараах зарчмуудад тулгуурласан. Үүнд:

- Хүүхдийн эсрэг хүчирхийллийг **огтхон ч тэвчихгүй**;
- Хүүхдийн **хамгийн их сонирхдог зүйлийг ойлгон хүлээн зөвшөөрч, хөхиүлэн дэмжих**;
- Хүүхэд хамгаалах **хариуцлагаа** хамтын болгох;
- Хүүхдийн эсрэг хүчирхийллээс урьдчилан сэргийлэх **эрсдэлийн менежментийн** арга зам ашиглах;
- Хүүхдийн эсрэг хүчирхийлэл гарсан бүх тохиолдлыг **мэдэгдэж, хариу өгөх**.

5. Транспэрэнси Интернэшнл Монгол ТББ-ийн хүүхдийн өмнө хүлээх үүрэг, амлалт

Транспэрэнси Интернэшнл Монгол ТББ-нь хүүхэд хамгааллын арга хэмжээнүүдийг стандартын хамгийн өндөр түвшинд хэрэгжүүлж, цаашид ч энэ байдлаа хадгалах үүрэг, амлалт өгсөн. Үүнд дараах зүйлс багтана:

- Транспэрэнси Интернэшнл Монгол ТББ-тэй холбоотой бүх гэрээнд бүх тал энэ бодлогын нөхцөл, шаардлагыг мөрдлөг болгохоо хүлээн зөвшөөрөх;
- Бүх төсөл болон үйл ажиллагааны эрсдэлийн үнэлгээнүүдэд хүүхэд хамгаалалтай холбоотой эрсдэлийг тусгах;
- Хүүхэд хамгаалалтай холбоотой соёлын онцлог бүхий асуудлуудыг төслийн эрсдэлийн менежментийн тусгай стратеги, сургалт, хариу өгөх журмуудад нэгтгэн оруулах;
- Урьдчилан сэргийлэх хүүхэд хамгааллын арга хэмжээнүүдийг стандартын хамгийн өндөр түвшинд хэрэгжүүлэх;
- Хүн ажилд авах, шалгах үйл явцыг хүүхэд аюулгүй байдлаар цогц хэлбэрээр ашиглах;
- Транспэрэнси Интернэшнл Монгол ТББ-ийн холбогдох ажилтан, төлөөлөгчид зориулсан хүүхэд хамгааллын сургалтыг тогтмол зохион байгуулах;
- Хүүхэд хамгааллын чиглэлээр биеэ хэрхэн авч явах тухай дүрэмтэй байх бөгөөд Транспэрэнси Интернэшнл Монгол ТББ-ийн холбогдох бүх ажилтан, төлөөлөгч уг дүрмийг хүлээн зөвшөөрч, гарын үсэг зурах;
- Тодорхой бөгөөд орчин үеийн тайлагнах журамтай байх бөгөөд үүнийг Транспэрэнси Интернэшнл Монгол ТББ-ийн ажилтан, төлөөлөгчид мэдэж байх;
- Тайлагнах ба хариу өгөх механизмийн хүрээнд улсын хууль тогтоомжууд, үйл явцууд, орон нутгийн нөөц бололцоог анхааралдаа авах;
- Хэрэв ажилд орох хүсэлтэй хүн нь хүүхдийн аюулгүй байдал, сайн сайханд хүлээн зөвшөөрөхийн аргагүй эрсдэл гаргаж байсан бол тухайн хүнийг ажилд авахгүй байх;
- Транспэрэнси Интернэшнл Монгол ТББ-тэй холбоотой ажлын бүх гэрээнд Транспэрэнси Интернэшнл Монгол ТББ-нь хүүхэд хамгааллын тал дээр биеэ хэрхэн авч явах тухай дүрмийг зөрчсөн ажилтныг ажлаас халах, үүргээс нь түтгэлзүүлэх эсхүл үүргийг нь бусдад шилжүүлэх эрхтэй гэдгийг тодорхойлох;
- Хүчирхийллийн хэрэг гарсан тохиолдолд албан ёсоор мөрдлөг эхлэхийг хүлээхийн зэрэгцээ тухайн хэргийг чанд нууцлан, бусдад ил гаргахгүй байх.

6. Хүүхэд хамгааллын тал дээр биеэ хэрхэн авч явах тухай дүрэм

**Хүлээн зөвшөөрөгдөх зан байдал**

Транспэрэнси Интернэшнл Монгол ТББ -ийн ажилтан нь:

- Хүүхэдтэй харилцахдаа арьс өнгө, хүйс, нас хэл, шашин шүтлэг, улс төрийн эсхүл бусад үзэл бодол, хөгжлийн бэрхшээл, эсхүл бусад статус ямар байхаас үл хамааран хүндэтгэх;
- Хүүхэдтэй харилцахдаа Транспэрэнси Интернэшнл Монгол ТББ-ийг төлөөлөн хашиж буй албан тушаалтайгаа зохистой хэлбэрээр биеэ авч явах;
- Хүүхдийн аюулгүй байдал ба сайн сайхны талаар ямар нэг санаа зовоосон зүйл байгаа бол Транспэрэнси Интернэшнл Монгол ТББ-ийн Тайлагнах журмын дагуу нэн даруй мэдэгдэж, шийдвэр гаргах үед журмын зөв шударга байдлыг баталгаажуулан мөрдлөг болгох;

- Хүүхэдтэй ажиллаж байх үедээ бусдад харагдаж байх, хүүхдийн ойр орчим ажиллахдаа аль болох өөр хүнийг хажуудаа байлгах;
- Хүүхдэд нөлөөлж болзошгүй шийдвэр гаргахдаа хүүхдийг сонсож, оролцох боломж олгох;
- Монгол улсын бүх холбогдох хууль тогтоомж болон уригч орны хууль тогтоомжийг мөрдлөг болгоно. Үүнд хүүхдийн хөдөлмөртэй холбоотой хөдөлмөрийн тухай хууль тогтоомж багтана;
- Хүүхдийн аюулгүй байдлын тухай байгууллагын бодлого, удирдамжийг дагаж мөрдөх.

### **Хүлээн зөвшөөрөгдөхгүй зан байдал**

*Транспэрэнси Интернэшнл Монгол ТББ*-ийн ажилтанд дараах зүйлсийг хориглоно. Үүнд:

- Хүүхэдтэй харилцахдаа зохисгүй, зовоосон, хараан доромжилсон, сексийн өдөөн хатгасан, эсхүл соёлын хувьд мэдрэмжгүй хэл яриа ашиглах эсхүл ийм зан байдал харуулах;
- Хүүхдийн нэр төрийг гутаасан, дайрч доромжилсон, сексийн өдөөн хатгасан, хараан доромжилсон эсхүл соёлын хувьд зохисгүй эсхүл мэдрэмжгүй үйл ажиллагааны аливаа хэлбэрт хүүхдийг татан оролцуулах;
- Сексийн үйлчилгээ эсхүл үйлдэлд төлбөр төлөх зэргээр хүүхдийг секст эсхүл энэ төрлийн үйл ажиллагааны аливаа хэлбэрт татан оролцуулах;
- Хүүхэд шархдах эсхүл гэмтэл, бэртэл авах зэрэг гэнэтийн эрсдэлтэй тохиолдол үүссэнээс бусад тохиолдолд дагалдах том хүнгүйгээр хүүхдийг гэртээ оруулахгүй байх;
- Аливаа хэрэгслээр дамжуулан хүүхдийн порнограф үзэх;
- Хараа хяналтгүй хүүхдийн ойр орчим унтах;
- Хүүхдийн нас эсхүл хөгжлийн үе шатанд тохиромжгүй, эсхүл хүүхдийн боловсрол эзэмших, амарч зугаалах цагтай нь давхацсан, эсхүл бэртэл, гэмтэл авах ихээхэн эрсдэлтэй байдалд оруулах гэр ахуйн эсхүл бусад төрлийн ажил, хөдөлмөрт хүүхдийг авч ажилуулах;
- Тусгай хүүхдийг тусгайлан авч үзэх эсхүл дэмжиж туслах;
- Хүүхдийн эцэг эх эсхүл асран халамжлагчийн зөвшөөрөлгүйгээр зохисгүй хэлбэрээр зураг авах компьютер, гар утас, камер, гэрэл зургийн аппарат зэрэг нь ашиглах тоног төхөөрөмжид багтах бөгөөд зөвхөн эдгээрээр хязгаарлагдахгүй ;
- Бие махбодын хүч хэрэглэн дайрах, сахилгын арга хэмжээ авах, эсхүл хүүхдийг шийтгэх;
- Хүүхдэд зохисгүй байдлаар эсхүл соёлын хувьд мэдрэмжгүй хэлбэрээр хүрэх. Эмнэлгийн шууд үйлчилгээ үзүүлдэг ажилтны хувьд Австралийн болон хилийн чанад дахь салбарын хамгийн сайн практик удирдамжийг мөрдлөг болгоно.

### **7. Хүүхдийн зургийг ашиглах фото зургийн бодлого**

*Транспэрэнси Интернэшнл Монгол ТББ*-ийн ажилтнууд ажлын зориулалтаар хүүхдийн зургийг авч, видео бичлэг хийхдээ дараах зүйлсийг баримтлах ёстой. Үүнд:

- Хувийн зураг үйлдвэрлэх орон нутгийн уламжлал эсхүл хязгаарлалтыг үнэлж, мөрдлөг болгох;
- Хүүхдээс эсхүл хүүхдийн эцэг эх, асран халамжлагчаас албан ёсны зөвшөөрөл авах. Энэ хүрээнд хүүхдийн зургийг хэрхэн ашиглах талаар тайлбар өгөх шаардлагатай;
- Хүүхдийн фото зураг, кино, видео болон DVD нь эмзэг эсхүл ноомой хэлбэрээр бус, харин нэр төртэй ба хүндлэлтэй хэлбэртэй байх. Хүүхдийг хангалттай хувцас өмсгөх бөгөөд хүүхэд сексийн шинжтэй ямар нэг байрлалтай харагдах ёсгүй;
- Хүүхдийн зураг нь тухайн хам сэдэв болон баримтын үнэн зөв төлөөлөл болж байгаа эсэхийг нягтлах;

- Хүүхдийн зургийг электрон хэлбэрээр бусдад илгээхдээ тухайн файлын гарчиг нь хүүхдийг хэн болох талаар мэдээллийг баттай нууцалсан байх;
- Хүүхдийн зургийг олон нийтийн зориулалтаар ашиглах үед тухайн хүүхдийн хэн болох талаарх мэдээллийг баттай нууцалсан байх.



## 8. Хүчирхийллийн тохиолдлыг мэдэгдэх ба түүнд хариу өгөх

### **Хүүхдийн эсрэг хүчирхийллийн талаар мэдэгдэх, тайлагнах**

Хүүхдийн эсрэг хүчирхийллийн талаар сэжигтэй эсхүл мэдэгдсэн тохиолдлыг холбогдох менежер болон *Транспэрэнси Интернэшнл Монгол ТББ*-ийн холбогдох хүнд яаралтай мэдэгдэх ёстой. Ийм бүх тохиолдлыг *Транспэрэнси Интернэшнл Монгол ТББ*-ийн Хүүхэд хамгааллын бодлогын хүчирхийлэл гарсан тохиолдлыг мэдэгдэх үйл явцын дагуу мэдэгдэж, зохион байгуулна (Хавсралт 2).

### **Хүүхдийн эсрэг хүчирхийллийн мэдэгдэлд хариу өгөх удирдамж**

1. *Транспэрэнси Интернэшнл Монгол ТББ*-ийн ажилтнаас болж хүүхэд хүчирхийлэлд өртсөн бүх тохиолдлыг *Транспэрэнси Интернэшнл Монгол ТББ*-н ухацтай авч үзнэ;
2. Бүх мэдэгдлийг нэгд нэггүй сайтар мөрдөн шалгана;
3. Хүчирхийллийн тохиолдлыг мэдэгдсэн тохиолдолд дараах журмыг мөрдлөг болгоно. Үүнд:

### **Ноцтой бус хэргийн талаарх мэдэгдэл**

Хүүхдийн эсрэг хүчирхийллийн ноцтой бус мэдэгдэл гэдэг нь хүүхдэд шууд эрсдэл учруулахгүй бөгөөд тухайн мэдэгдэл үнэн зөв байсан эсэхийг санал болгож буй мэдэгдэл юм. Эдгээр тохиолдол нь шинж чанарын хувьд ноцтой боловч үүнд хариу өгөх хугацааны хувьд яаралтай бус байдаг. Тухайлбал, хүүхдийн порнограф.

1. Тухайн тохиолдлыг *Транспэрэнси Интернэшнл Монгол ТББ*-ийн Хүчирхийллийн тохиолдлыг мэдэгдэх, хариу өгөх журмын дагуу баримтжуулж, мөрдлөг явуулна;
2. Тухайн тохиолдлыг мөрдөхдөө буруутгаж буй болон мэдэгдэл гаргасан хохирогчийн хувийн нууцлалд бүрэн хүндлэлтэй хандах бөгөөд тухайн хэрэгт оролцсон хүмүүсийн эрх, сайн сайхныг нэн тэргүүнд авч үзэн “мэдэх хэрэгцээ, шаардлага”-ын үндсэн дээр холбогдох мэдээллийг дамжуулна;
3. Буруутгагдаж буй хүнд өөрийн үзэл бодол/тухайн хэргийн талаарх хувилбараа илэрхийлэх боломжийг олгоно;
4. Хүүхэд хүчирхийллийн талаар ховорхон тохиолдолд худал ярьдаг болохыг баримтжуулан нотолсон тул хүчирхийллийг мэдэгдсэн хохирогч хүүхдийн үзэл бодлыг нухацтай авч үзэх хэрэгтэй;
5. Хүчирхийллийн хэрэг гарсан нь үндэслэлтэйгээр тогтоогдсон бол доорх сахилгын арга хэмжээг авах бөгөөд зөвхөн эдгээрээр хязгаарлагдахгүй. Үүнд:
  - Сануулга өгөх;
  - Ажил, үүргийг нь түр хугацаанд түтгэлзүүлэх;
  - Ажил, үүргээс нь чөлөөлөх.

Сахилгын арга хэмжээ нь тухайн хэргийн шинж чанар ба хэр ноцтой болохоос шалтгаалах бөгөөд холбогдох Менежер үүнийг шийдэж, улмаар *Транспэрэнси Интернэшнл Монгол ТББ*-ийн оффист тухайн хэргийг баримтжуулсны үндсэн дээр танилцуулна.

### **Ноцтой хэргийн талаарх мэдэгдэл**

Ноцтой мэдэгдэл нь хүүхдийн эрүүл мэнд, сайн сайханд шууд эрсдэл учруулах аюултай, үнэн зөв мэдэгдэл юм. Тухайлбал, сексийн зохисгүй үйл ажиллагаа.

1. Хүчирхийллийн талаарх мэдэгдэл нь тухайн хэрэг гарсан улсын хууль тогтоомж болон Монгол улсын хууль тогтоомжийг аль алиныг нь зөрчсөн тохиолдолд тухайн хэргийн талаар холбогдох

эрх бүхий байгууллагад нэн даруй мэдэгдэж, буруутай ажилтныг ажлаас нь түр чөлөөлөн мөрдөн байцаалт болтол хүлээлгэнэ;

2. Буруутгагдаж буй хүний нууцлал ба эрхийг хангахад бүх хүчин чармалтай тавих бөгөөд тухайн хэрэгтэй холбоотой мэдээллийг зөвхөн “мэдэх хэрэгцээ, шаардлагын үндэс”-н дээр хуваалцана;
3. Хэрэв тухайн хэрэг Биеэ хэрхэн авч явах тухай дүрмийг зөрчсөн бол (энэ нь улсын хууль тогтоомжийг зөрчөөгүй бол) буруутай хүнийг ажлаас нь түр чөлөөлж, мөрдөн байцаалт болтол хүлээлгэнэ;
4. Биеэ хэрхэн авч явах тухай байгууллагын дүрмийг зөрчсөн тохиолдолд бүх нөхцөл байдлыг авч үзсэний үндсэн дээр зохих арга хэмжээг авна;
5. Тухайн мэдэгдэл нь хуурамч эсхүл тогтоогдохгүй байгаа тохиолдолд буруутгагдсан хүний эрхийг хамгаалж, сэргээхийн тулд бүх хүчин чармайлтаа тавина;
6. Тухайн хэрэг нь Монгол улсын хууль тогтоомжийг зөрчсөн тохиолдолд хохирогчийн эрхийг хамгаалахад шаардлагатай гэж үзэхээс бусад тохиолдолд хувийн нууцыг нь цаашид ашиглахгүй болно.
7. Мөрдлөг явуулахад шаардлагатай гэж үзвэл, *Транспэрэнси Интернэшнл Монгол ТББ*-нь хуулийн зөвлөгөө авах, мөн холбогдох эрх бүхий байгууллагаас зөвлөгөө авах талаар бодолцож, энэ талаар анхааралдаа авах хэрэгтэй болно.

#### 9. Хүн ажилд авах, лавлагааг шалгах

Хэрэв ажилд орох хүсэлтэй хүн нь хүүхдэд хүлээн зөвшөөрөх аргагүй эрсдэл учруулж байсан бол *Транспэрэнси Интернэшнл Монгол ТББ*-нь үүнийг мэдсээр байж түүнийг ажилд авах, сайн дурын ажилтан болгон авахыг зөвшөөрч болохгүй. .

Түүнчлэн:

- *Транспэрэнси Интернэшнл Монгол ТББ*-ын бүх шинэ ажилтан цагдаагийн бичиг (ял, шийтгэл авч байсан, гэмт хэрэгт холбогдож байсан эсэх талаар) авах шаардлагатай эсхүл өөрийн гэмт хэргийн түүхийн талаар албан ёсны мэдэгдэл хийх (Хавсралт 1).
- Өмнөх ажил олгогч / лавлагаа өгөгчөөс амаар лавлагаа авахдаа хамгийн багадаа хоёр хүнээс авна. Лавлагаа өгөх хүн нь ажилд орох хүсэлтэй хүний түнш, гэр бүлийн хүн эсхүл хамаатан садан байж болохгүй. Хүүхэдтэй ажиллана гэж үзсэн ямар ч ажил үүргийн хувьд, тухайн хүн хүүхэдтэй ажиллах үүрэгт ажилд эсхүл хүүхэдтэй хараа хяналтгүй тогтмол ажиллахад хэр тохиромжтой талаар лавлагаа өгөх хүнээс асууна. Хүүхэдтэй ажиллах ба харилцахтай холбоотойгоор тухайн хүний талаар ямар нэг санаа зовоосон асуудал байгаа эсэх, эсхүл түүний талаар санал гомдол гарч байсан эсэхийг лавлагаа өгөх хүнээс мөн асууна.
- Шинэ ажилтан өмнө нь хүүхдийн мөлжлөгтэй холбоотой хэргээр ял, шийтгэл эдэлж байсан эсэх талаар бичгээр мэдэгдэх шаардлагатай.
- Ажилд орохоор өргөдөл гаргагч нь өөрийгөө мөн болохыг нотолсон баримт бичгээр хангах шаардлагатай.
- Хүүхэдтэй ажиллана гэж үзсэн ямар ч ажил үүргийн хувьд *Транспэрэнси Интернэшнл Монгол ТББ*-ийн ажлын ярилцлагын үйл явцад ажилд орох хүсэлтэй хүний сонирхож буй албан тушаалтай нь холбоотойгоор тухайн хүний хүүхэд рүү чиглэсэн хандлага, хүүхэдтэй ажиллаж

байсан туршлага, арга барилыг шалгахын тулд зан байдалд тулгуурласан шууд хүүхэдтэй ажиллах тухай асуултуудыг тусгаж өгөх шаардлагатай. Хэрэв тохиромжтой бол асуултуудыг доорх жагсаалтаас гарган авч болно. Үүнд:

- ✓ Та өмнө нь үүнтэй төстэй ажил үүрэг гүйцэтгэн хүүхэдтэй ажиллаж/сайн дураараа ажиллаж байсан уу? Тухайн ажлынхаа юунд нь дуртай байсан бэ? Тулгарч байсан хүндрэл юу байв?
- ✓ Үйл ажиллагаанд оролцох хүсэлгүй хүүхдийн асуудлыг та хэрхэн шийдвэрлэдэг байв?
- ✓ Хараа хяналттай байхад татгалзахгүй зүйл танд бий юу?
- ✓ Энэ хөтөлбөрийн хүрээнд хүүхэдтэй ажиллах хүслийг юу танд төрүүлэв/яагаад хүүхэдтэй ажиллахыг хүсч байгаа вэ?

#### 10. Хүүхэд хамгааллын талаарх боловсрол, сургалт

*Транспэрэнси Интернэшнл Монгол ТББ*-ын бүх шинэ ажилтанд дараах зүйлсийг заавал өгнө. Үүнд:

- Байгууллагын Хүүхэд хамгааллын бодлогын тухай танилцуулга. Уг танилцуулгад хүүхдэд аюулгүй байгууллага бий болгож, цаашид авч явах Транспэрэнси Интернэшнл ба хувь хүний үүрэг хариуцлагын талаар, мөн хүүхэдтэй эсхүл хүүхдэд-мэдрэг материалтай харилцах үеийн зохистой зан байдлын талаар хэлэлцүүлэг багтах ёстой.
- *Транспэрэнси Интернэшнл Монгол ТББ*-ын Хүүхэд хамгааллын бодлого болон холбогдох журмуудын хуулбар.

### **Үүрэг, амлалтын тухай албан ёсны мэдэгдэл**

Байгууллагын ажилчид энэ бодлогыг мөрдлөг болгох үүрэг, амлалт өгөх бөгөөд гарын үсэг зурсан хувийг байгууллагын оффист хадгална. Бусад ажилтануудыг мэдээллээр хангах зохион байгуулалтыг холбогдох ажилтан Э.Мөнхжаргал болон оффисын ажилтан Б.Анударь нар хариуцна.

Энэхүү баримт бичигт гарын үсэг зурснаар үүнд тодорхойлсон нөхцлүүдийг би ойлгож, хүлээн зөвшөөрч буйгаа илэрхийлж байна. Уг баримт бичигт нарийвчлан заасан хууль ёсны болоод ёс зүйн үүргүүдээ ойлгож байгаа болно. Энэхүү бодлого, Биеэ хэрхэн авч явах тухай дүрмийг зөрчвөл энэ нь *Транспэрэнси Интернэшнл Монгол ТББ*-тэй хийсэн ажлын гэрээ цуцлагдах үндэслэл болох, түүнчлэн эрүүгийн гэмт хэрэгт татагдах магадлалтай гэдгийг би ойлгож байна.

Би дараах зүйлийг албан ёсоор мэдэгдэж байна. Үүнд:

- *Транспэрэнси Интернэшнл Монгол ТББ*-ийн Хүүхэд хамгааллын бодлогыг уншиж, ойлгосон.
- Би *Транспэрэнси Интернэшнл Монгол ТББ*-ийн Хүүхэд хамгааллын бодлогод тодорхойлсон журмуудын хүрээнд ажиллах болно.
- Бусад хүн хүүхдийг хүчирхийлсэн аливаа сэжигтэй тохиолдлыг нэн даруй мэдэгдэх болно.

- Би хүүхэд эсхүл залуу хүмүүсийн эсрэг бие махбодын ба бэлгийн хүчирхийллийн гэмт хэрэгт буруутгагдаж, ял, шийтгэл эдэлж байгаагүй.
- Хэрэв *Транспэрэнси Интернэшнл Монгол ТББ*-ийн үйл ажиллагаанд хамрагдах явцад хүүхдийн эсрэг хүчирхийллийн талаар миний эсрэг гомдол гарвал тухайн мэдэгдлийг холбогдох эрх бүхий байгууллагатай хамтран нэгд нэггүй мөрдөх болно гэдгийг би ойлгож байгаа болно.
- *Транспэрэнси Интернэшнл Монгол ТББ*-д ажилд орсон хүний хувьд хүүхдийг хүчирхийлэл, мөлжлөгийн чанартай үйлдэл эсхүл зан байдал гаргах, эсхүл ингэж ойлгогдож болох үйлдлээс зайлсхийх нь миний үүрэг, хариуцлага гэдгийг ойлгож байгаа болно.
- Ажил авах үйл явцын хүрээнд гэмт хэргийн бүртгэл ба лавлагааг шалгах зэрэг бүх шаардлагатай мэдээлэл авах эрхийг *Транспэрэнси Интернэшнл Монгол ТББ*-д олгож байна.
- Би *Транспэрэнси Интернэшнл Монгол ТББ*-ын хүүхэд хамгааллын талаарх сургалтад хамрагдах хүсэлтэй гэдгээ баталж байна.

Огноо	Нэр	Албан тушаал	Гарын үсэг

**Хавсралт 1: Гэмт хэргийн бүртгэлийн маягтын албан ёсны мэдэгдэл**

## Гэмт хэргийн бүртгэлийн маягтын албан ёсны мэдэгдэл

Ажил орох хүсэлт гаргагчийн нэр:		Сонирхож буй албан тушаал:	
Та өмнө нь ямар нэг гэмт хэрэгт холбогдон ял, шийтгэл эдэлж байсан уу?		Тийм <input type="checkbox"/>	Үгүй <input type="checkbox"/>
Хэрэв тийм бол дэлгэрэнгүй тайлбарлана уу:			

**Жич:** Хэрэв та хүүхэдтэй тогтмол харилцаатай байх албан тушаалд орох хүсэл гаргасан бол, (энэ нь тогтмол эсхүл тогтмол бус байж болно), та **бүх** ял, шийтгэл эсхүл эрүүгийн гэмт хэрэг ба сануулга, эсхүл хүлээгдэж буй шүүхийн шийдвэрийн талаарх дэлгэрэнгүй мэдээлэл өгөх шаардлагатай.

Өмнө нь 18-аас доош настай хүүхэдтэй ажиллаж байхдаа ажлаасаа халагдаж байсан эсхүл сахилгын арга хэмжээ авхуулж байсан тохиолдолд танд бий юу?	Тийм <input type="checkbox"/>	Үгүй <input type="checkbox"/>
Хэрэв тийм бол, дэлгэрэнгүй тайлбарлана уу:		
Та өмнө нь албан ёсны донго, эцсийн сануулга эсхүл цагдаагийн сануулга авч байсан уу?	Тийм <input type="checkbox"/>	Үгүй <input type="checkbox"/>
Хэрэв тийм бол дэлгэрэнгүй тайлбарлана уу:		
Таны ажил орох өргөдөлтэй холбоотой байж болох өөр мэдээлэл байгаа юу? Тухайлбал, хүлээгдэж буй шүүхийн шийдвэр гэх мэт.	Тийм <input type="checkbox"/>	Үгүй <input type="checkbox"/>
Хэрэв тийм бол дэлгэрэнгүй тайлбарлана уу:		
Гарын үсэг:	Огноо:	

### Хавсралт 2: Хүүхдийн эсрэг хүчирхийллийн хэргийг мэдэгдэх хуудас

## ХҮҮХДИЙН ЭСРЭГ ХҮЧИРХИЙЛЛИЙН ХЭРГИЙГ МЭДЭГДЭХ ХУУДАС

Өөрийн зүгээс өгөх боломжтой аль болох дэлгэрэнгүй мэдээллээр аль болох олон хэсгийг бөглөнө үү. Энэхүү маягт нь нууцлалын зэрэглэлтэй болно.

Байршил:
Таны нэр:
Таны албан тушаал:
Хүүхдийн нэр:
Хүүхдийн нас/төрсөн өдөр:
Хүүхдийн хаяг (хэрэв мэдэгдэж байгаа бол):
Эцэг эх/асран хамгаалагч/асран халамжлагчийн нэр, хаяг (хэрэв мэдэгдэж байгаа бол):
Хэрэг гарсан өдөр, цаг:
Уг хэрэгт холбогдсон ажилтан (хэрэв байгаа бол):
Уг хэрэг болсон газар:
Таны ажигласан зүйл:
Санаа зовоосон асуудал/сэжиг/хэргийн тухай дэлгэрэнгүй мэдээлэл: Юу болсныг нарийн тодорхойлох: цаг, өдөр, тухайн хэрэгт оролцсон хүний (хүмүүсийн) нэр(с), хүүхдээс ажиглагдсан зан байдлын эсхүл бие махбодын шинж тэмдэг, бусад дэлгэрэнгүй мэдээлэл:
Хүүхэдтэй хийсэн яриаг дэлгэрэнгүй бич:

Өдийг хүртэл авсан арга хэмжээ (хэрэв байгаа бол):	
Холбоо барьсан гаднын байгууллага (өдөр, цаг)	
Цагдаа Тийм/үгүй	Хэрэв тийм бол – цагдаагийн аль хэсэг:  Холбогдсон хүний нэр, дугаар:  Хүлээн авсан зөвлөгөөний дэлгэрэнгүй:
Нийгмийн үйлчилгээ Тийм/үгүй	Хэрэв тийм бол – ямар байгууллага:  Холбогдсон хүний нэр, дугаар:  Хүлээн авсан зөвлөгөөний дэлгэрэнгүй:
<i>Транспэрэнси Интернэшнл Монгол ТББ-ийн хүүхэд хамгааллын ажилтан эсхүл хүүхдийн талаар харилцах хүн/менежер:</i>	Холбогдсон хүний нэр, дугаар:  Хүлээн авсан зөвлөгөөний дэлгэрэнгүй:
Орон нутгийн эрх бүхий байгууллага:	Хэрэв тийм бол – ямар байгууллага:  Холбогдсон хүний нэр, дугаар:  Хүлээн авсан зөвлөгөөний дэлгэрэнгүй:
Бусад байгууллага:	Ямар байгууллага:  Холбогдсон хүний нэр, дугаар:  Хүлээн авсан зөвлөгөөний дэлгэрэнгүй:
Гарын үсэг:  Нэрээ гаргацтай бичих:  Огноо:	

# Транспэрэнси Интернэшнл Монгол ТББ



## Хүүхэд хамгааллын эрсдэлийн бүртгэл

*Хөтөлбөр, үйл ажиллагааны хүрээнд хүүхдэд тохиолдож болзошгүй эрсдэл, аюулыг олж тогтоон шийдвэрлэх*

Эрсдэлийн бүртгэлийг хариуцагч	Б. миа
Баталсан	О.Батбаяр
Олгосон огноо	2018-11-16
Дахин хянах огноо	2019 оны 12 сар



Байгууллагын үйл ажиллагааны хүрээнд хүүхдэд хор хөнөөл учруулж болзошгүй эрсдэл ба арга замыг олж тогтоох хэрэгтэй. Зөвхөн эрсдэлийг олж тогтоосноор хүүхдийн эсрэг хүчирхийллийг бууруулах, түүнээс урьдчилан сэргийлэхэд чиглэсэн стратеги гаргах боломжтой.

Эрсдэл гэдэг нь ямар нэг зүйл буруугаар эргэх магадлалтай байдлыг хэлнэ. Эрсдэлийн менежмент гэдэг нь гэнэтийн золгүй хэрэг ба таагүй хэрэг гарах магадлалыг олж тогтоон тухайн хэрэг гарах боломжийг бууруулахад чиглэсэн арга хэмжээ авах гэсэн утгатай.

Дараах хүснэгтийг хүүхэд хамрагдах эсвэл хүүхэдтэй холбогдох хөтөлбөр, үйл ажиллагаа зохион байгуулагдах үед ашиглана.

Үйл ажиллагааны төрөл	Хүүхдэд учирч болзошгүй эрсдэл	Хүүхдэд учрах эрсдэлийг бууруулах протокол/журам	Стратеги/авах арга хэмжээг хэн хариуцах вэ? Хэзээ?
n/a	n/a	n/a	n/a